

ӨГҮҮЛЭЛ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр: Гаалийн тарифын хэлэлцээ хийхэд анхаарах зарим асуудал

Нямдаагийн Отгонсайхан 

Доктор (Ph.D)

Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль
otgonsaikhan@num.edu.mn

Өлзий-Очирын Номинцэцэг 

Доктор (Ph.D)

Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль
nomintsetseg@num.edu.mn

Энхтуяагийн Дэлгэржаргал 

Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль
22m1num0060@stud.num.edu.mn

Хураангуй. Монгол Улс анхны Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ)-ийг Япон улстай байгуулан 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Дараагийн хэлэлцээрийг БНСУ-тай байгуулахаар тохиролцож, албан ёсны хэлэлцээг 2023 оны 12 дугаар сараас эхлүүлээд байна. Хэлэлцээрийн хүрээнд барааны болон үйлчилгээний худалдаа, худалдаанд хамаарах хөрөнгө оруулалт болон оюуны өмчийн эрх гээд олон асуудлыг хөнддөг. Гаалийн тарифын хэлэлцээ нь барааны худалдааны бүлгийн үндсэн асуудал бөгөөд бусад бүлэгтэй нягт уялдаатай байж хэлэлцээрээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлдэг. Иймээс гаалийн тарифын хэлэлцээ хийхэд шаардлагатай чанарын болон тоон судалгааг урьдчилан хийж, судалгаанд суурилсан шийдвэрийг гаргах нь чухал. Энэ ажлын хүрээнд БНСУ-ын бусад оронтой байгуулсан хэлэлцээрийн төрөл, хэлэлцээ үргэлжилсэн хугацаа, Вьетнамтай хийсэн тарифын хэлэлцээний үр дүн зэргийг судалж, Монгол Улсын тарифын хөнгөлөлтийн жагсаалтын санал, БНСУ-д хүргүүлэх хүсэлтийг боловсруулахад шаардлагатай харьцангуй давуу талын шинжилгээг хийж, тарифын хэлэлцээ хийхэд анхаарах зарим асуудлыг тодорхойлсон болно.

• Corresponding author

© The Author(s), 2023



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

 <https://orcid.org/0000-0002-1301-5397>

 <https://orcid.org/0009-0000-1467-7010>

 <https://orcid.org/0009-0003-6757-9782>

Received: 12 November, 2023

Accepted: 05 January, 2024

Түлхүүр үг. Гаалийн тарифыг бууруулах, тэглэх; Хөнгөлөлттэй тариф; Нэн тааламжтай тариф; Тарифын хөнгөлөлтийн жагсаалт; Харьцангуй давуу талын индекс

I. Удиртгал

Улс орнууд өөр хоорондоо Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын хүрээнд олгодог нэн тааламжтай нөхцөлөөс илүү хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдаа хийхээр харилцан тохиролцох замаар Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) байгуулдаг ба нэн тааламжтай тариф (MFN)-ыг бууруулах, тэглэх хэлэлцээ нь хэлэлцээрийн үндсэн асуудал болдог². Сүүлийн жилүүдэд зарим орнууд эдийн засгийн бусад салбарын асуудлаар уг хэлэлцээрийг өргөжүүлэн Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) хэмээн нэрлэж байна³.

Худалдааны гол түнш орнуудтайгаа Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нь Монгол Улсын худалдааны бодлогын нэн тэргүүний зорилтын нэгд тооцогддог ба Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-д “Гадаад худалдааны бодлогын хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж хөгжүүлэх, экспортын бараа бүтээгдэхүүний нэмүү өртгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн уялдуулсан тарифыг бий болгох, шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортлох таатай нөхцөлүүдийг урьдчилан бүрдүүлэх, үүний тулд тодорхой улс орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудалд онцгойлон анхаарах нь

зүйтэй” гэж тусгасан⁴.

Монгол Улс анхны ЭЗТХ-ийг Япон улстай байгуулж 2016 оноос хэрэгжүүлээд байгаа ба БНХАУ, БНСУ, Евроазийн эдийн засгийн холбоотой энэ төрлийн хэлэлцээр байгуулах боломжийн талаар хамтарсан судалгааны ажлыг хийгээд байгаа билээ.

Монгол Улс, БНСУ-ын Ерөнхийлөгч нарын 2016 оны харилцан айлчлалаар хоёр орны хооронд ЭЗТХ байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны ажлыг эхлүүлэх тохиролцоонд хүрч, улмаар талууд “Хамтарсан судалгаа хийх ажлын даалгавар”-т гарын үзэг зурснаар судалгааг 2017 онд гүйцэтгэж, 2021 онд шинэчилсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 2 дугаар сард БНСУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр улсын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засаг, хөгжлийн сайд, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний дэд сайд нар “Монгол Улс, БНСУ хоорондын ЭЗТХ-ийг эхлүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл”-д гарын үсэг зуржээ. Энэ хүрээнд талуудын холбогдох албаны хүмүүс ажлын түвшинд хамтран ажиллаж, ЭЗТХ-ийн хамрах хүрээ, зорилго, талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон Ажлын даалгаврын төслийг харилцан санал солилцсоны үндсэн дээр эцэслэн

² Отгонсайхан, 2010

³ Otgonsaikhan et al., 2022

⁴ Монгол Улсын Засгийн газар, 2019

боловсруулсан.

Улмаар Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны Чөлөөт худалдааны хэлэлцээрийн бодлогын асуудал хариуцсан дарга нар 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр “Монгол Улс, БНСУ хоорондын ЭЗТХ-ийг эхлүүлэх тухай Ажлын даалгавар”-т Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан. Ингэснээр ЭЗТХ-ийн яриа хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн бөгөөд талууд хэлэлцээрийн эхний шатны хэлэлцээг 2023 оны 12 дугаар сард БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулахаар харилцан тохиролцжээ⁵.

Монгол Улс, БНСУ-ын хооронд ЭЗТХ байгуулах асуудлаар өмнө хэд хэдэн судалгаа хийгдсэн ба эдгээр нь гол төлөв хоёр улс хэлэлцээр байгуулах боломжтой эсэхэд илүү чиглэж байсан⁶.

ЭЗТХ-ийн яриа хэлэлцээг талууд албан ёсоор эхлүүлсэн учраас энэ судалгаагаар хэлэлцээрийн үндсэн хэсэг болох тарифын хэлэлцээг амжилттай хийхэд зайлшгүй шаардлагатай чанарын болон тоон судалгааг хийхийг зорьсон

юм.

Уг ажлын хүрээнд БНСУ-ын бусад оронтой байгуулсан хэлэлцээрийн хэлбэр, хэлэлцээ үргэлжилсэн хугацаа зэргийг судалж, үүнээс Вьетнамтай хийсэн тарифын хэлэлцээний үр дүнг нарийвчлан авч үзсэн. Тарифын хэлэлцээний хамгийн чухал хэсэг нь тарифын хөнгөлөлтийн үндэсний жагсаалтын төслийг талууд боловсруулж харилцан тохиролцох асуудал байдаг. Иймээс Монгол Улсын тарифын хөнгөлөлтийн үндэсний жагсаалтыг боловсруулахад шаардлагатай Харьцангуй давуу талын индексийн шинжилгээ хийж, Олон улсын худалдааны төвийн экспортын потенциалыг тооцох аргачлал ашиглан цаашид БНСУ-аас Монгол Улсын зах зээлд экспортлох боломж бүхий барааг тодорхойлсон. Түүнчлэн тарифын хэлэлцээний хүрээнд Монгол Улсын талаас өөрийн экспортын барааны гаалийн тарифыг бууруулах чиглэлээр БНСУ-д хүсэлт хүргүүлэхэд анхаарах зарим асуудлын талаар судалж тодорхой дүгнэлт, саналыг гаргасан болно.

II. БНСУ-ын бусад оронтой байгуулсан Чөлөөт худалдааны хэлэлцээр, Вьетнамтай хийсэн тарифын хэлэлцээний үр дүн

Өнөөдрийн байдлаар БНСУ нь 60 гаруй улсыг хамруулсан чөлөөт худалдааны 21 хэлэлцээртэй. Үүнээс 18 нь Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ), Энэтхэг болон Индонези улстай Иж бүрэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (СЕРА-Comprehensive Economic Partnership Agreement)

байгуулсан, 2022 оноос Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (RCEP-Regional Comprehensive Economic Partnership)-ийн гишүүн болсон⁷.

БНСУ-ын бусад оронтой ЧХХ байгуулсан хугацаа харилцан адилгүй байгаа ба хамгийн багадаа 11 сар,

⁵ Эдийн засаг, хөгжлийн яам, 2023

⁶ Otgonsaikhan et al., 2014 болон Гадаад харилцааны яам, 2021

⁷ World Trade Organization, 2023a

хамгийн ихдээ Канадтай байгуулсан зарцуулжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг хэлэлцээрт 9 жил 2 сарын хугацааг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. БНСУ-ын бусад орнуудтай байгуулсан ЧХХ-ийн товч мэдээлэл

	Улс, бүс нутаг	Хэлбэр	Хэлэлцээрийн үйл явц			
			Эхэлсэн	Гарын үсэг зурсан	Зарцуулсан хугацаа, жил	Хэрэгжиж эхэлсэн
1	Чили	ЧХХ	1999.12	2003.02	3.2 жил	2004.04.01
2	Сингапур	ЧХХ	2004.01	2005.08	1.7 жил	2006.03.02
3	ЕФТА ⁸ 4 улс	ЧХХ	2005.01	2005.12	11 сар	2006.09.01
4	ASEAN ⁹ 10 улс	ЧХХ	2005.02	2006.08(Бараа) 2007.11(Үйлчилгээ) 2009.06 (ХО)	1.6 жил (Бараа) 2.9 жил (Үйлчилгээ) 4 жил (ХО)	2007.06 (Бараа) 2009.05(Үйлчилгээ) 2009.09 (ХО)
5	АНУ	ЧХХ	2006.06 2018.01	2007.06 2018.09(хянан хэлэлцэх)	1.8 жил	2012.03.15 2019.02 (нэмэлт өөрчлөлт)
6	Энэтхэг	СЕРА ¹⁰	2006.03	2009.08	3.5 жил	2010.01.01
7	ЕХ11 27 улс	ЧХХ	2007.05.	2010.10	3.5 жил	2011.07.01 (түр) 2015.12.13 (бүрэн)
8	Перу	ЧХХ	2009.03	2011.03	2 жил	2011.08.01
9	Турк	ЧХХ	2010.04	2012.08(бараа) 2015.05(Үйлчилгээ, ХО)	2.4 жил	2013.05 (Бараа) 2018.08(Үйлчилгээ, ХО)
10	Колумб	ЧХХ	2009.12	2013.02	3.2 жил	2016.07.15
11	Австрали	ЧХХ	2009.05	2014.04	4.11 жил	2014.12.12
12	Канад	ЧХХ	2005.07	2014.09	9. 2 жил	2015.01.01
13	Хятад	ЧХХ	2012.05	2015.06	3.1 жил	2015.12.20
14	Шинэ Зеланд	ЧХХ	2012.05	2015.06	3.1 жил	2015.12.20
15	Вьетнам	ЧХХ	2012.09	2015.05	2.8 жил	2015.12.20
16	Төв Америк ¹² 5 улс	ЧХХ	2015.06	2018.02	2.8 жил	2019.10.01

⁸ European Free Trade Association: Швейцар, Норвеги, Исланд, Лихтенштейн

⁹ Association of Southeast ASEAN Nations: Малайз, Сингапур, Вьетнам, Мьянмар, Индонез, Филиппин, Бруней, Лаос, Камбож, Тайланд

¹⁰ Comprehensive Economic Partnership Agreement - Иж бүрэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр

¹¹ Европын холбоо: Австри, Бельги, Чех, Кипр, Дани, Эстони, Финлянд, Франц, Герман, Грек, Унгар, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Мальта, Нидерланд, Польш, Португал, Словак, Словени, Испани, Швед, Болгар, Румын, Хорват

¹² Төв Америк: Никарагуа, Хондурас, Коста Рика, Сальвадор, Панам

17	Англи	ЧХХ	2016.12	2019.08	2.8 жил	2021.01.01
18	RCEP ¹³ 16 улс		2012.11	2020.11.15	8 жил	2022.01.01
19	Израил	ЧХХ	2016.05	2021.05.13	5 жил	2022.12.01
20	Индонез	СЕРА ¹⁴	2012.03	2020.12	8.9 жил	2023.01.01
21	Камбож	ЧХХ	2020.07	2022.01.29	1.6 жил	2023.01.01

Эх сурвалж: ДХБ-ын мэдээлэлд тулгуурлан боловсруулав

Түүнчлэн Филиппинтэй (2019.06) ЧХХ байгуулах яриа хэлэлцээг эхлүүлж, тохиролцоонд хүрч хамтарсан тунхаглал гаргаад байгаа ч хараахан хэрэгжиж эхлээгүй байгаа юм.

БНСУ нь Хятад-Япон (2012.11), ОХУ (2019.06), Малайз (2019.06) улстай ЧХХ, Экватор (2015.08)-тай Стратегийн эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр¹⁵, MERCOSUR (2018.05)-тай Худалдааны хэлэлцээр¹⁶, Узбекистан (2021.01)-тай Тогтвортой худалдаа, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр¹⁷ байгуулахаар яриа хэлэлцээ эхлүүлж, хэд хэдэн удаагийн хэлэлцээ хийгээд байгаа ч тодорхой тохиролцоонд хүрээгүй байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд БНСУ нь ЧХХ-ийн арвин туршлагатай бөгөөд бид тус улсын байгуулсан хэлэлцээрийг урьдчилан судалж, өөрийн байр суурийг тодорхойлох нь туйлын чухал.

ДХБ-ын гишүүн орнуудад ЧХХ байгуулах эрх нь нээлттэй бөгөөд хэлэлцэн тохирогч талууд тарифын хэлэлцээг Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)¹⁸-ийн I болон XXIV зүйл, эсхүл “Enabling clause”¹⁹ заалтыг үндэслэн хийдэг.

БНСУ нь бусад орнуудтай ЧХХ байгуулахдаа ТХЕХ-ийн XXIV зүйлийг ашигласан ба Монгол Улстай ч энэ заалтыг баримтлах нь тодорхой байна. Уг заалтаар хэлэлцэн тохирогч талууд хоорондын худалдааны дийлэнх хэсгийн²⁰ гаалийн тарифыг тодорхой хугацаанд²¹ чөлөөлөх шаардлагатай болдог.

Дээрх заалтын хүрээнд БНСУ-ын бусад оронтой байгуулсан хэлэлцээрээс манай улстай ижил төстэй нөхцөлтэй байж болох Вьетнамтай байгуулсан ЧХХ-ийн²² хүрээнд гаалийн тарифын хэлэлцээг хэрхэн хийсэн үр дүнг судалж, дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

¹³ Regional Comprehensive Economic Partnership

¹⁴ Comprehensive Economic Partnership Agreement

¹⁵ SECA - Strategic Economic Cooperation Agreement

¹⁶ TA - Trade agreement

¹⁷ STEP - Agreement for Sustainable Trade and Economic Partnership

¹⁸ World Trade Organization, 1994: General agreement on tariffs and trade (GATT)

¹⁹ World Trade Organization, 1979: Токиогийн үе шатны (1971) дүнд байгуулсан хөгжиж буй орнуудад ялгавартай, илүү тааламжтай нөхцөлөөр хариу хандах, тэдний оролцоог нэмэгдүүлэх тухай шийдвэрээр (*товчлоор Enabling Clause буюу Эрх олгох тухай заалт хэмээн нэрлэж занисан*) зохицуулах болсноор буурай хөгжилтэй орнууд тарифын хэмжээг бууруулах, тарифын бус арга хэмжээг хүчингүй болгох үүднээс холбогдох гэрээ, хэлэлцээр байгуулах боломж бүрджээ.

²⁰ substantially all the trade

²¹ Reasonable period

²² 2015 оны 12 сарын 20-оос хэрэгжүүлж эхэлсэн

Хүснэгт 2. БНСУ, Вьетнамын ЧХХ-ийн хүрээнд БНСУ-ын талаас гаалийн тарифыг бууруулсан байдал

Он	БНСУ-ын тарифын жагсаалт дах барааны нэр төрөл	БНСУ-ын тарифын жагсаалтад эзлэх хувь, %	БНСУ-ын Вьетнамаас авсан импортын хэмжээ (2012-2014) ^а сая US\$	БНСУ-ын импортод Вьетнамын эзлэх хувь, % 2012-2014
2015 (“0”тариф)	1956	<u>16.0</u>	1043.3	15.2
2015	9303	<u>76.0</u>	5349.9	78.1
2017	216	<u>1.8</u>	15.5	0.2
2019	137	<u>1.1</u>	41.6	0.6
2021	7	<u>0.1</u>	4.6	0.1
2024	49	<u>0.4</u>	42.8	0.6
2029	3	<u>0.0</u>	0.2	0.0
Remain Dutiable	572	<u>4.7</u>	351.7	5.1
Нийт	12 243	<u>100.0</u>	6849.6	100.0

Эх сурвалж: Free Trade Agreement Between The Republic Of Korea And Viet Nam тайланд үндэслэн боловсруулав²³

Дээрх хүснэгтээс үзэхэд, ЧХХ байгуулах үед БНСУ-ын нэн тааламжтай тарифын жагсаалтад 12243 нэр төрлийн бараа байсан ба түүний 16 хувь нь “0” тарифтай байсан бол 2015 онд хэлэлцээр байгуулснаар 76 хувийг “0” болгож, тарифын жагсаалт дах барааны 92 хувь нь “0” тарифтай болжээ. Улмаар 15 жилийн хугацаанд буюу 2029 он гэхэд энэ хэмжээг 95 хувьд хүргэхээр гаалийн тарифыг бууруулах хуваарь хийжээ. Эндээс үзэхэд, бид ч БНСУ-тай тарифын хэлэлцээ хийхдээ тариф чөлөөлөх хугацааг 10 жилээр хязгаарлах шаардлагагүй²⁴. Мөн Япон улстай

байгуулсан хэлэлцээрийн туршлагаа ашиглан 20 жилээр ч хийх боломжтой гэж үзэж байна.


Хэлэлцээр байгуулахын өмнөх 3 жил буюу 2012-2014 онд Вьетнам нь БНСУ-аас 6849.6 сая долларын **бараа импортолсон** ба хэлэлцээр байгуулсан өдрөөс 93.3 хувийнх нь гаалийн тарифыг тэглэжээ.

БНСУ нь ХАА-н бараанд өндөр тариф ногдуулдаг ба Вьетнам улстай ЧХХ байгуулах үеийн тарифыг хэлэлцээр байгуулснаар хэрхэн бууруулсныг харьцуулан дараах зурагт харуулав.

²³ World Trade Organization, 2017

²⁴ ТХЕХ-ийн XXIV-т хэлэлцээрт хамруулсан барааны гаалийн тарифыг боломжийн хугацаанд (within a reasonable length of time) тэглэхээр заасан ба ЧХХ байгуулсан орнуудын туршлагаас үзэхэд, гаалийн тарифыг 10 жилийн хугацаанд тэглэх нийтлэг хандлага байдаг. Гэвч энд тодорхой хугацаа заагаагүй учраас хэлэлцэгч талууд боломжит хугацааг тохирч болохоор байгаа юм.

Зураг 1. БНСУ-ын гаалийн тарифын дундаж хувь, нэн тааламжтай тариф болон Вьетнамтай байгуулсан ЧХХ-ийн хөнгөлөлттэй тариф, БТКУС-ийн эхний 44 бүлгээр



Эх сурвалж: Free Trade Agreement Between The Republic Of Korea And VietNam тайлан²⁵

Дээрх зургаас үзэхэд, БНСУ нь БТКУС-ийн 09-13 болон 33 дугаар бүлгийн бараанд маш өндөр буюу 300-аас дээш хувийн гаалийн тариф ногдуулдаг бөгөөд хэлэлцээрийн хүрээнд маш бага буулт хийжээ. Эдгээр бүлгийн бараа нь Монгол Улсын хувьд экспортын боломж өндөр бараа гэдгийг анхаарч тарифын хэлэлцээнд орох шаардлагатай юм.

БНСУ-ын одоогийн мэдээллээс үзэхэд, Монгол Улсын экспортын гол нэр төрлийн бараа болох хушны самрын гаалийн тариф 566.8 хувь байгааг анхааралдаа авах нь зүйтэй болов уу.

Дараах хүснэгтэд хоёр улсын хооронд байгуулсан ЧХХ-ийн хүрээнд Вьетнам улсын талаас гаалийн тарифын хэлэлцээг хэрхэн хийсэн үр дүнг харуулав.

Хүснэгт 3. БНСУ, Вьетнамын ЧХХ-ийн хүрээнд Вьетнамын талаас гаалийн тарифыг бууруулсан байдал

Он	Вьетнамын тарифын жагсаалт дах барааны нэр төрөл	Вьетнамын тарифын жагсаалтад эзлэх хувь, %	Вьетнамын БНСУ-аас авсан импортын хэмжээ (2012-2014) ^а сая US\$	Вьетнамын импортод БНСУ-ын эзлэх хувь, % 2012-2014
2015-“0” тариф	3052	31.8	10821.3	56.0
2015	4499	46.9	3090.9	16.0
2016	337	3.5	910.3	4.7
2017	15	0.2	273.9	1.4
2018	440	4.6	2214.7	11.5
2019	44	0.5	49.6	0.3

²⁵ World Trade Organization, 2017

2021	36	0.4	61.5	0.3
2022	6	0.1	10.6	0.1
2024	104	1.1	452.2	2.3
2029	3	0.0	4.9	0.0
Remain dutiable	1053	11.0	1420.6	7.4
Нийт	9589	100.0	19 310.6	100.0


Эх сурвалж: *Free Trade Agreement Between The Republic Of Korea And Viet Nam тайланд үндэслэн боловсруулав*²⁶.

Дээрх хүснэгтээс үзэхэд, ЧХХ байгуулах үед Вьетнамын нэн тааламжтай тарифын жагсаалтад 9589 нэр төрлийн бараа байсан ба түүний 31.8 хувь нь “0” тарифтай байсан бол 2015 онд хэлэлцээр байгуулснаар 46.9 хувийг “0” болгож, тарифын жагсаалт дах барааны 78.7 хувьд хүрчээ. Улмаар 15 жилийн хугацаанд буюу 2029 он гэхэд

89 хувьд хүргэхээр гаалийн тарифыг бууруулах хуваарь хийжээ.


Вьетнам Улсын хувьд БНСУ-тай харьцуулахад гаалийн тарифын хувь хэмжээ бага бөгөөд ЧХХ байгуулах үеийн гаалийн тарифыг хэлэлцээр байгуулснаар хэрхэн бууруулсан эсэхийг харьцуулан дараах зургуудад харуулав.

Зураг 2. Вьетнам улсын гаалийн тарифын дундаж хувь, нэн тааламжтай тариф болон БНСУ-тай байгуулсан ЧХХ-ийн хөнгөлөлттэй тариф, БТКУС-ийн 1-24 дүгээр бүлгээр



²⁶ World Trade Organization, 2017

Зураг 3. Вьетнам улсын гаалийн тарифын дундаж хувь, нэн тааламжтай тариф болон БНСУ-тай байгуулсан ЧХХ-ийн хөнгөлөлттэй тариф, БТКУС-ийн 25-97 дугаар бүлгээр



Эх сурвалж: Free Trade Agreement Between The Republic Of Korea And Viet Nam тайлан²⁷

Дээрх зургаас үзэхэд, Вьетнам улсын ХАА-н барааны гаалийн тарифын түвшин БНСУ-тай харьцуулахад 10 дахин доогуур байсан бөгөөд БТКУС-ийн зарим бүлгийн барааны гаалийн тарифыг бууруулаагүй байна. Жишээ нь 04, 12, 13. Түүнчлэн аж үйлдвэрийн бараанаас нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний гаалийн тариф нэлээд өндөр байгаа ба хэлэлцээрийн хүрээнд 15 орчим хувиар л бууруулжээ.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд, бид БНСУ-тай тарифын хэлцэл хийхдээ тариф бууруулах хугацааг 15-20 жилээр хийх боломжтой ба гаалийн тарифыг бууруулах, “0” болгох барааг 90%-д

хүргэх шаардлагагүй гэж үзэж болно.

Судлаач Ким ЧХХ-ийн тарифын хэлэлцээний хүрээнд нэгдүгээрт барааны худалдааны хэсгийн бичвэр, хоёрдугаарт уг хэсгийн үндсэн хавсралт болох тарифын хөнгөлөлтийн үндэсний жагсаалтыг талууд хэлэлцэн тохиролцох явдал гэж тодорхойлсон байдаг²⁸. Тиймээс дараагийн хэсэгт Монгол Улсын тарифын хөнгөлөлтийн жагсаалтын санал болон БНСУ-ын тарифын хөнгөлөлтийн жагсаалтад хүргүүлэх хүсэлтийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгааны үр дүнг тусгав.

III. Монгол Улсын тарифын хөнгөлөлтийн жагсаалт

Монгол Улсын тарифын хөнгөлөлтийн жагсаалтын саналыг оловсруулахдаа ТХЕХ-ийн XXIV зүйлийг баримтлахаас гадна, үндэсний хөгжлийн бодлого стратегид нийцүүлэх шаардлагатай бөгөөд бид ямар бараан

дээр тарифын хэлэлцээ хийх үү гэдгээ урьдчилан тодорхойлсон байх нь чухал²⁹.

Олон улсын худалдааны онолоор бол аливаа улс орон өөрийн харьцангуй давуу тал бүхий барааны үйлдвэрлэлээр

²⁷ Мөн тэнд

²⁸ Kim, 2017

²⁹ Отгонсайхан, 2012

төрөлжиж, тэрхүү харьцангуй давуу тал бүхий бараагаа худалдаалах нь үр ашигтай гэж үздэг³⁰. Эрдэмтэн Бела Баласса анх харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг ашиглах санааг дэвшүүлсэн³¹. Тэрээр тодорхой барааны харьцангуй давуу талын индексийг тухайн барааны тухайн улсын нийт экспортод эзлэх хувийн жинг тухайн барааны дэлхийн нийт экспортод эзлэх хувийн жинд харьцуулах замаар томъёолсон.

Уг индексийг ЧХХ-ийн үнэлгээнд ашигладаг³² ба бид экспортын харьцангуй давуу талын индексийг ашиглан талуудын нийлүүлэх, импортын харьцангуй давуу талын индексийг ашиглан талуудын худалдан авах боломж хамгийн өндөр барааг тодорхойлох оролдлого хийсэн юм.

Бид энэ хэсэгт БНСУ-ын экспортын, Монгол Улсын импортын харьцангуй давуу талын индексийг тооцож, давхцалыг гаргаснаар БНСУ-аас импортоор орж ирэх боломж өндөртэй барааг тодорхойллоо. Энэхүү тооцоог

хийхдээ Олон улсын худалдааны төвийн статистик мэдээллийг ашигласан ба БТКУС –ийн мөрийн түвшинд 6295 нэр төрлийн бараан дээр шинжилгээ хийсэн болно. Энэ судалгаа нь нэг талаас БНСУ-ын сонирхлын бүлгийн барааг тодорхойлох, нөгөө талаас Монгол Улсын дотоодын үйлдвэрлэлийн салбарын бодлоготой зөрчилдөх бараа байгаа эсэхийг судлахад хувь нэмэр үзүүлэх юм.

Судалгаанаас үзэхэд, БНСУ-ын экспортын 919, Монгол Улсын импортын 896 нэр төрлийн бараа харьцангуй давуу талтай байна. Эдгээрээс экспорт, импортын харьцангуй давуу талын давхцалыг гаргаж, БНСУ-аас импортлох боломжтой 144 барааг тодорхойлсон бөгөөд үүнээс МУ-ын импортлох боломж хамгийн өндөр 30 барааг Монгол Улсын импортын (MNG RMA), БНСУ-ын экспортын (KOR RXA) харьцангуй давуу талын индекс болон МУ-ын нэн тааламжтай тариф (MFN)-ын хамтаар дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Монгол Улсын импортын харьцангуй давуу тал (MNG RMA), БНСУ-ын экспортын харьцангуй давуу тал (KOR RXA) бүхий барааны давхцал

БТКУС код	Барааны нэр	KOR RXA	MNG RMA	МУ-ын MFN тариф, %
271019	Биодизель агуулаагүй дунд зэргийн тос ба бэлдмэл, нефть эсвэл битумэн эрдэс бодис	2.4	6.0	5.0
271012	Хөнгөн тос, бэлдмэл, нефть эсвэл битумэн эрдэс бодисын эзлэхүүнтэй > 90%	1.2	4.3	5.0
330499	Гоо сайхны эсвэл нүүр будалтын бэлдмэл ба арьс арчилгааны бэлдмэл (эмээс бусад)	3.4	1.1	5.0

³⁰ Батнасан et al., 2012

³¹ Balassa, 1965

³² Plummer et al., 2011

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр:
Гаалийн тарифын хэлэлцээ хийхэд анхаарах зарим асуудал

БТКУС код	Барааны нэр	KOR RXA	MNG RMA	МУ-ын MFN тариф, %
870324	Хүн тээврийн зориулалттай моторт болон бусад төрлийн моторт тээврийн хэрэгсэл,	4.6	4.4	5.0
870340	Автомашинны болон бусад тээврийн хэрэгслийг үндсэндээ тээвэрлэх зориулалттай	2.4	14.4	5.0
842952	Өөрөө явагч механик экскаватор, экскаватор, экскаватор ачигч, 360 ° эргэлттэй	3.8	16.9	5.0
843149	8426, 8429, 8430 гарчгийн машин механизмын хэсэг	2.3	5.6	5.0
850710	“Стартерийн батерей” поршений хөдөлгүүрийг асаахад ашигладаг хар тугалга хүчилтөрөгчийн аккумулятор	5.7	1.4	5.0
841810	Тусдаа гаднах хаалгатай, хөргөгчтэй хосолсон хөлдөөгч	3.6	2.0	5.0
271320	Газрын тосны битум	4.3	7.6	5.0
730890	Төмөр эсвэл ган төмөр хийц, хийцүүдийн хэсэг (гүүр, гүүрэн хэсгүүдийг эс тооцвол)	1.1	5.9	5.0
401120	Автобус, ачааны машинд ашиглагддаг шинэ хийн резин, хаймар дугуй	1.2	2.3	5.0
330790	Депилятор болон бусад үнэртэй ус, ариун цэвэр, гоо сайхны бэлдмэлүүд	5.7	2.6	5.0
240220	Тамхи эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар	1.0	7.8	30.0
842121	Усыг шүүж цэвэрлэх зориулалттай машин, хэрэгсэл	2.5	1.2	5.0
901812	Хэт авианы сканердах аппарат	4.4	2.9	0.0
481019	Шилэн агуулаагүй бичих, хэвлэх эсвэл бусад график зорилгоор ашигладаг цаас, цаасан самбар	4.9	1.4	5.0
870210	Арав буюу түүнээс дээш (жолоочийг оруулаад) тээвэрлэх зориулалттай моторт тээврийн хэрэгсэл	1.5	1.7	5.0
841989	Цахилгаан халаалттай эсэхээс үл хамааран эмчилгээний зориулалттай машин механизм, үйлдвэр, лабораторийн тоног төхөөрөмж	2.6	1.7	5.0
721633	Төмөр эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн булан, хэлбэрт болон сортын төмөр	5.3	2.3	5.0
391810	Хуйлаастай эсвэл хавтгай хэлбэрийн, өөрөө наалддаг буюу наалддаггүй, хуванцар шалны бүрээс; энэ бүлгийн тайлбар 9-д тодорхойлогдсон, хана, таазны хуванцар бүрээс	2.4	1.1	5.0
842890	Ачааг өргөх, зөөх, ачих, буулгах зориулалтын бусад техник хэрэгсэл	1.5	1.2	5.0
854460	> 1.000 вольт хүчдэлтэй цахилгаан дамжуулагч, тусгаарлагч утас, кабель	2.5	3.6	5.0

БТКУС код	Барааны нэр	KOR RХА	MNG RMA	МУ-ын MFN тариф, %
190230	Чанасан эсвэл өөр хэлбэрээр бэлтгэсэн гоймон (чихмэл ороогүй)	5.1	19.6	5.0
842720	Авто ачигч, үйлдвэр аж ахуйн зориулалттай ачих-буулгах, эсвэл зөөх төхөөрөмжтэй бусад ачигч	1.8	1.2	5.0
390761	Поли “этилен терефталат”, анхдагч төлөвт байгаа, зуурамтгай чанар нь >= 78 мл/г байна.	1.8	5.9	5.0
731210	Төмөр эсвэл ган томсон утас, олс ба кабель (цахилгаан тусгаарлагчгүй)	2.6	3.6	5.0
840890	Дотоод шаталтын дөл-асаагуурт бүлүүрэн хөдөлгүүр (дизель эсвэл хагас дизель хөдөлгүүр)	1.2	1.8	5.0
721391	Халуунаар цувьсан, зөв бус хэлбэрийн ороомог байдалтай, төмөр эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн цулдан болон туйван	2.0	5.8	5.0
841330	Шингэн зүйлсийн зарцуулалтыг хэмжих төхөөрөмжтэй эсвэл төхөөрөмжгүй насос	1.0	1.6	5.0

Эх сурвалж. БНСУ-ын экспортын, МУ-ын импортын харьцангуй давуу талын индексийг Олон улсын худалдааны төвийн статистик мэдээлэлд үндэслэн судлаач тооцоолов.³³


Дээрх хүснэгтээс үзэхэд, БНСУ-ын экспортын харьцангуй давуу талтай барааны дийлэнх нь нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн байсан бөгөөд Монгол Улс ихэвчлэн нефть химийн бүтээгдэхүүн, автомашин, машин механизмын импортлох хандлагатай байна. БНСУ-аас импортлох боломж хамгийн өндөр барааны хувьд зөвхөн тамхи, сигарын гаалийн тариф өндөр байгаа бол бусад

барааны хувьд 5% байгаа нь тарифын хэлэлцээнээс ашиг олох магадлал бага байгаа гэдгийг анхаарах шаардлагатай юм.

Түүнчлэн цаашид БНСУ-аас Монгол Улсын зах зээлд экспортлох боломж бүхий барааг Олон улсын худалдааны төвийн экспортын потенциалыг тооцох аргачлал ашиглан тооцож потенциал өндөр эхний 10 барааг дараах зурагт харуулав.

³³ Олон улсын худалдааны төв, 2023b

Зураг 4. БНСУ–аас Монгол Улсын зах зээлд экспортолх боломжтой эхний 10 бараа



Эх сурвалж: Олон улсын худалдааны төвийн мэдээлэлд үндэслэн боловсруулав³⁴

- Тайлбар:**
- Хаалтад Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн ангиллын кодыг
 - Өнгөний хувьд: Цайвар - экспортын потенциал, Гүн экспортын потенциалыг ашигласан байдлыг харуулж байгаа болно.

Дээрх зургаас үзэхэд, БТКУС–ийн 8703 зүйлд хамаарах хөнгөн тэрэг, гол төлөв хүн тээвэрлэх зориулалтаар зохион бүтээсэн бусад моторт тээврийн хэрэгслийг БНСУ-аас Монгол Улсад экспортолх потенциал хамгийн өндөр байгаа бөгөөд нийт потенциалынхаа дөнгөж 9 хувийг ашиглаж байна. Энэ нь Япон улстай ЭЗТХ байгуулж шинэ суудлын машины гаалийн тарифыг тэглэсэнтэй холбоотой байж болох юм.

Цаашид Монгол Улс баруун талдаа хүрдтэй автомашиныг улсын бүртгэлд бүртгэхгүй байхыг авто тээврийн хуульд тусгах асуудал яригдаж³⁵ байгаа тул БНСУ-аас суудлын автомашины

импорт нэмэгдэх боломж өндөр байна.

Түүнчлэн БНСУ нь Монгол Улсад экспортолх гоймонгийн экспортын потенциалын 37 хувийг ашиглаж байгаагаас үзэхэд энэ чиглэлийн бүтээгдэхүүний импорт нэмэгдэх боломжтой байна. Тухайн бүтээгдэхүүн нь Монгол Улсын дотооддоо үйлдвэрлэх боломжтой бараа учраас гаалийн тарифын хэлэлцээний үед тарифыг бууруулах категорийг зөв тодорхойлох шаардлагатай гэж харагдлаа.

Харин БТКУС–ийн 8704 зүйлд хамаарах ачаа бараа тээвэрлэх моторт тээврийн хэрэгсэл болон Согтууруулах бус ундааг БНСУ-аас

³⁴ Олон улсын худалдааны төв, 2023а

³⁵ vip76, 2022

Монгол Улсад экспортлох потенциал байгаа ч бидний зүгээс потенциалаа 100 хувь ашиглажээ. Энэ нь ЧХХ-ийн хүрээнд гаалийн тарифыг бууруулснаар бусад улсаас эдгээр бүтээгдэхүүнийг импортлох урсгал өөрчлөгдөх магадлалтай гэдгийг харуулж байна.

Тиймээс БНСУ-аас Монгол Улс руу экспортлох потенциал бүхий барааг тэдний сонирхлын бүлгийн бараа гэж үзээд гаалийн тарифын хэлэлцээ хийхдээ анхааралдаа авч наймаалцах шаардлагатай гэж үзлээ.

Мөн тарифын хэлэлцээ хийхдээ

Монгол Улсын эдийн засгийн салбарын бодлоготой уялдуулан гаалийн тарифыг өндөр тогтоосон барааны гаалийн тарифыг чөлөөлөхгүй байхад анхаарч тарифын хөнгөлөлтийн жагсаалтыг боловсруулах нь чухал тул Монгол Улсын нэн тааламжтай тарифын жагсаалтыг тарифын түвшнээр нь судалсан юм. БТКУС-ийн үндэсний кодын задаргаагаар 6325 нэр төрлийн бараа энэхүү жагсаалтад байгаа ба эдгээр барааны нэн тааламжтай тарифыг дараах хүснэгтэд бүлэглэн харуулав.

Хүснэгт 5. МУ-ын нэн тааламжтай тариф (MFN)

Гаалийн тарифын түвшин	0%	5%	6.5%	10%	15%	20%	25%	30%	35%	40%
Барааны тоо (БТКУС-ийн үндэсний кодоор нийт 6325 нэр төрлийн бараанаас)	89	6047	2	12	87	68	1	10	3	6
Нийт бараанд эзлэх хувь, %	1.4	95.6	0.03	0.2	1.4	1.1	0.02	0.2	0.05	0.1

Эх сурвалж: МУ-ын нэн тааламжтай тарифын жагсаалтад (2023 он) үндэслэн боловсруулав.

Дээрх хүснэгтээс харахад, 6047 бараа буюу нийт барааны 95.6 хувь нь 5 хувийн гаалийн тарифтай байна. Хэрэв тарифын хэлэлцээг одоогийн нэн тааламжтай тарифын жагсаалтад үндэслэн ТХЕХ-ийн XXIV зүйлийн дагуу дор хаяж нийт барааны 10 хувьд нь гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэхгүй үлдээнэ гэж үзвэл 600 гаруй нэр төрлийн бараа байхаар байна. Эдгээр бараанд 6.5-аас дээш гаалийн тарифтай бүх бараа, мөн 5 хувийн тарифтай 400 гаруй барааны гаалийн тарифыг бууруулах шаардлагагүй гэдгийг

анхаарах хэрэгтэй болов уу. Түүнчлэн хоёр орны хоорондын худалдааны үнийн дүнг тарифын хэлэлцээ хийхэд авч үздэг учраас суурь болгож авч үзэх оны худалдааны тоон мэдээлэл дээр нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй юм.

Мөн ЭЗТХ байгуулж БНСУ-аас импортлох барааны гаалийн тарифыг бууруулснаар улсын төсөвт ямар нөлөө үзүүлэхийг судлах шаардлагатай болдог. Монгол Улсын төсвийн орлогод татварын орлого 80 гаруй хувийг, үүнээс импортын гаалийн татварын орлого 5-7

орчим хувийг эзэлдэг³⁶ бөгөөд 2022 оны нэгдсэн төсвийн орлогод (18.5 их наяд) импортын гаалийн татварын орлого 6.8% (1.25 их наяд) эзэлж байна³⁷. Өмнө хийгдсэн судалгаанаас үзэхэд, БНСУ-тай ЧХХ байгуулж гаалийн тарифыг бууруулснаар улсын төсөвт 1 орчим хувийн сөрөг нөлөө үзүүлэх

бөгөөд бусад татварт эергээр нөлөөлөх замаар татварын нийт орлогод эерэг нөлөө үзүүлэх хандлагатай байсан³⁸ ба уг судалгааг сүүлийн үеийн тоон мэдээллээр шинэчлэн хийхэд нөхцөл байдал өөрчлөгдсөн байхыг үгүйсгэхгүй.

IV. БНСУ-ын тарифын хөнгөлөлтийн жагсаалтад хүсэлт хүргүүлэх

Бид өөрийн тарифын хөнгөлөлтийн жагсаалтын төслийг боловсруулж БНСУ-тай тарифын хэлэлцээ хийхээс гадна БНСУ-ын тарифын хөнгөлөлтийн жагсаалтын төсөл дээр ажиллаж өөрийн сонирхлын бүлгийн барааны гаалийн тарифыг бууруулах хүсэлтээ өгч хэлэлцээ хийх шаардлагатай билээ.

Тиймээс энэ хэсэгт Олон улсын худалдааны төвийн статистик мэдээллийг ашиглан БТКУС-ийн мөрийн түвшинд 6295 нэр төрлийн бараан дээр Монгол Улсын экспортын, БНСУ-ын импортын харьцангуй давуу талын индексийн шинжилгээг хийж,

БНСУ-ын зах зэх зээлд Монгол Улсын сонирхлын бүлгийн барааг тодорхойлох оролдлого хийлээ.

Шинжилгээнээс үзэхэд, Монгол Улсын 100 нэр төрлийн бараа экспортын, БНСУ-ын 1389 нэр төрлийн бараа импортын харьцангуй давуу талтай байлаа. Эндээс экспорт, импортын харьцангуй давуу талын давхцалыг гаргаж харахад 30 нэр төрлийн бараа МУ-аас БНСУ-д экспортлох боломж өндөр байсан ба дараах хүснэгтэд эдгээр барааны индексийг БНСУ-ын нэн тааламжтай гаалийн тариф (MFN)-ын хамт харуулав.

Хүснэгт 6. Монгол Улсын экспортын харьцангуй давуу тал (MNG RXA), БНСУ-ын импортын харьцангуй давуу тал (KOR RMA) бүхий бүтээгдэхүүний давхцал

БТКУС	Барааны нэр	MNG RXA	KOR RMA	БНСУ-ын MFN тариф, %
270112	Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш	81.0	5.5	0.0
260300	Зэсийн хүдэр ба баяжмал	76.2	2.2	0.0
260111	Төмрийн хүдэр болон баяжмал (төмрийн шатаасан пирит орно)	13.8	1.9	0.0

³⁶ Отгонсайхан, 2013, х-99

³⁷ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2023

³⁸ Батнасан et al., 2012, х-30

ОЛОН УЛС СУДЛАЛ

БТКУС	Барааны нэр	MNG RXA	KOR RMA	БНСУ-ын MFN тариф, %
270900	Түүхий нефть ба битумжсан эрдсээс гаргаж авсан түүхий газрын тос	1.1	2.5	3.0
260800	Цайрын хүдэр ба баяжмал	42.1	5.9	0.0
252921	Хайлуур жонш: жингийн 97% буюу түүнээс бага фторт кальци агуулсан	1338.2	2.4	2.0
260700	Хар тугалганы хүдэр ба баяжмал	30.2	9.5	0.0
261390	Молибдений хүдэр ба баяжмал (шарж ороогүй)	69.84	4.1	0.0
510531	Кашмир ямааны сэмлэсэн буюу самнасан ноолуур	1734.3	5.3	0.0
611012	Сүлжмэл свитер, джемпер, пуловер, кардиган, жилет болон эдгээртэй төстэй сүлжмэл эдлэл	21.8	1.4	13.0
270111	Чулуун нүүрс, нунтагласан ба бөөмнөрүүлсэн	8.0	6.0	0.0
050400	Мал амьтны (загаснаас бусад) шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан бүтэн эсвэл хэсэглэсэн өлөн гэдэс, давсаг, гүзээ	4.1	1.4	27.0
020422	Хонь, ямааны шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах	14.8	1.1	22.5
261100	Вольфрамын хүдэр ба баяжмал	115.8	3.9	0.0
610210	Эмэгтэйчүүд эсвэл охидын сүлжмэл пальто, богино хүрэм, нөмрөг, цув, юүдэнтэй хүрэм (түүнчлэн цанын хүрэм орно), салхи, борооны нимгэн хүрэм болон ижил төстэй сүлжмэл хувцас	43.3	2.0	13.0
621420	Шаль, ороолт, хүзүүний алчуур, толгойны алчуур, гивлүүр болон тэдгээртэй төстэй зүйлс	5.4	1.6	8.0
620211	Эмэгтэйчүүдийн эсвэл охидын оёмол пальто, богино хүрэм, нөмрөг, цув, юүдэнтэй хүрэм, салхи, борооны цув, хүрэм болон бусад	3.2	3.0	13.0
610441	Эмэгтэйчүүд, охидын, сүлжмэл костюм, хослол, пиджак, хүрэм, даашинз, банзал, өмдөн банзал, урт өмд, энгэрэвч мөрөвчтэй комбинезон, хагас урт өмд, богино өмд (усны хувцаснаас бусад)	22.1	1.1	13.0
611019	Сүлжмэл свитер, джемпер, пуловер, кардиган, жилет болон эдгээртэй төстэй сүлжмэл эдлэл	4.8	1.4	13.0
050790	Боловсруулаагүй эсвэл энгийн аргаар бэлтгэсэн боловч хэлбэр оруулаагүй зааны яс, яст мэлхийн хуяг, халимын яс, халимын сахал, бугын эвэр, салаа, эвэр туурай, хумс, савар, шувууны хошуу; эдгээрийн нунтаг, хаягдал	24.9	12.0	20.0
510529	Самнасан ноос (самнасан тайрмал ноос орно)	2.2	1.7	0.0
510539	Сэмлэсэн эсвэл самнасан, хонины ноос буюу мал, амьтны нарийн эсвэл бүдүүн үс, ноос, хялгас (самнасан тайрмал ноос орно)	8.1	3.9	0.0

БТКУС	Барааны нэр	MNG RXA	KOR RMA	БНСУ-ын MFN тариф, %
780199	Боловсруулаагүй хар тугалга (цэвэршүүлсэн хар тугалга ба жинд антигоми агуулсан хар тугалга хамаарахгүй)	1.7	1.0	1.0
511111	Хонины сэмлэсэн ноос эсвэл бусад мал, амьтны сэмлэсэн нарийн үс, ноосоор нэхсэн даавуу, > = 85% дээш жин, агууламжтай	16.8	2.1	13.0
620111	Эрэгтэйчүүдийн эсвэл хөвгүүдийн оёмол пальто, богино хүрэм, нөмрөг, цув, юүдэнтэй хүрэм (цанын хүрэм орно), салхи борооны цув, хүрэм	2.1	2.6	13.0
610451	Эмэгтэйчүүд, охидын, сүлжмэл костюм, хослол, пиджак, хүрэм, даашинз, банзал, өмдөн банзал, урт өмд, энгэрэвч мөрөвчтэй комбинезон, хагас урт-богино өмд	28.3	1.4	13.0
150600	Мал, амьтны гаралтай, цэвэршүүлсэн эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй бусад өөх, тос, түүний фракц	3.3	1.7	3.0
510510	Сэмлэсэн (анхан шатны бүдүүн самналт хийсэн) хонины ноос	29.7	4.2	0.0
510810	Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, мал, амьтны нарийн үс, ноосон сэмлэсэн эсвэл самнасан ээрмэл	2.2	2.5	8.0
051000	Цайвар бойшил, минж (тосон туулга), мануул болон хүдрийн заар; хатаасан цох; хатаасан буюу хатаагаагүй цөс; булчирхай болон бусад	4.2	4.9	8.0

Эх сурвалж. МУ-ын экспортын, БНСУ-ын импортын харьцангуй давуу талын индексийг Олон улсын худалдааны төвийн статистик мэдээлэлд үндэслэн судлаач тооцоолов.

Дээрх хүснэгтээс үзэхэд, Монгол Улсын харьцангуй давуу тал бүхий барааны дийлэнх хувийг олборлох үйлдвэрлэл, мал аж ахуйн гаралтай түүхий эд зэрэг байгалийн баялагт түшиглэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Харин БНСУ-ын импортын харьцангуй давуу талыг авч үзвэл электроникийн салбарт зэс, газрын ховор элемент; авто машин болон усан онгоцны үйлдвэрлэлийн салбарт зэс, төмөр; мөн металлургийн салбарт коксжих нүүрсний эрэлт өндөр байгаа ч ихэнхийн нь гаалийн тариф тэг, эсхүл

бага байгааг анхаарах хэрэгтэй.

БНСУ-ын импортын харьцангуй давуу талтай салбар болох электроник, автомашин, барилгын салбарт Монгол Улс хөрөнгө оруулалт татаж хамтарсан үйлдвэр байгуулах замаар зарим нэмүү өртөг шингэсэн барааг үйлдвэрлэж БНСУ-д экспортлох боломжийг бизнес эрхлэгчид эрэлхийлэх хэрэгтэй. Иймээс нэмүү өртөг шингэсэн эцсийн бэлэн бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэх (“0”) тарифын хэлэлцээ хийх нь чухал юм.

Малын гаралтай болон зэрлэг

жимс нь хүнс болон гоо сайхны бүтээгдэхүүний гол түүхий эд тул БНСУ-д экспортлох боломж харагдаж байна. Эдгээр барааны гаалийн тариф нэлээд өндөр байгаа ба гаалийн тарифыг тэглэх хэлэлцээ хийх шаардлагатай. Мөн эдгээр барааны эрүүл ахуй, стандартын асуудлыг хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй болов уу.

Мөн уламжлалт экспортын бараа болох БТКУС-ийн 61, 62 бүлэгт хамаарах нэхмэл сүлжмэлийн хэдэн нэр

төрлийн барааг нийлүүлэх боломжтой ба гаалийн тарифыг хэлэлцээр байгуулсан өдрөөс тэглэх асуудлыг ярих нь зөв.

Тарифын хэлэлцээг амжилттай хийж, гаалийн тариф “0” болсон ч эдгээр барааны гарал үүслийн дүрмийг сайтар тохирох, эрүүл ахуйн болон стандартын шаардлагыг хангах тал дээр хамтран ажиллах, салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг татах зэрэг асуудлыг орхигдуулж болохгүй юм.

V. Дүгнэлт, санал

БНСУ нь бусад орнуудтай байгуулсан ЧХХ-ийн хүрээнд тарифын хэлэлцээ хийхдээ ТХЕХ-ийн XXIV зүйлийг эрхзүйн үндэслэл болгосон ба уг заалтыг ASEAN-ий орнууд болон Энэтхэгтэй байгуулсан хэлэлцээр дээр “Enabling Clause” заалттай хослуулан ашигласан тохиолдол байна. Иймээс Монгол Улс нь БНСУ-тай тарифын хэлэлцээ хийхдээ энэ туршлагыг ашиглах боломжийг эрэлхийлэх, ингэхдээ 2 хувилбарын аль нь илүү үр ашигтай байх талаар нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай гэж үзлээ.

ТХЕХ-ийн XXIV зүйлийн хэлэлцээрийн оролцогч талууд хоорондын худалдааны “дийлэнх” хэсгийн гаалийн тарифыг бууруулах гэсэн заалт дээр тодорхой хувь, хэмжээ байхгүй тул Монгол Улс тарифын хэлэлцээ хийхдээ бусад орны жишгийг даган нийт худалдааны 90 хувьд хүргэнэ гэсэн зорилго тавихгүй байж болох ба өөрийн сонирхлын бүлгийн барааг тарифын хөнгөлөлтийн жагсаалтад БТКУС-ийн ангиллаар тодорхой оруулах нь чухал.

Түүнчлэн ЧХХ байгуулж буй

улс орнууд хоорондын худалдааны дийлэнх хэсгийн гаалийн тарифыг 10 жилийн хугацаанд чөлөөлөх гэсэн нийтлэг ойлголт байгаа ч БНСУ-ын хувьд хугацааг 15, 20 жилээр бусад орнуудтай тохирсон байгаа учраас дотоодод үйлдвэрлэх боломжтой барааны гаалийн тарифыг аль болох урт хугацаанд бууруулахаар хэлэлцээ хийж болохоор байна.

Хэлэлцээр байгуулах эрхзүйн үндэслэлийг тохирсны дараа тарифыг бууруулах хэлбэр, хугацааг сайтар тооцоолох нь зөв. Өөрөөр хэлбэл, тухайн барааны импортын гаалийн тарифыг бууруулж, тэг (“0”) болгосноор Монгол Улсын дотоодын үйлдвэрлэл, цаашлаад улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх бол тарифыг бууруулах, чөлөөлөх асуудлыг тухайн хэлэлцээрээс гадуур үлдээх; мөн тодорхой хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах шаардлагатай бол гаалийн тарифыг үе шаттайгаар, удаан хугацаанд чөлөөлөх зэргээр хэлэлцээрийн оролцогч талдаа саналаа оруулж, наймаалцаж болох юм.

Монгол Улс өөрийн эмзэг, хамгаалах шаардлагатай салбар болон

бараа бүтээгдэхүүнийг тодорхойлж, баримтлах стратегийг яаралтай тодорхойлох нь зүйтэй болов уу. Өмнө хийгдсэн судалгаанаас харахад, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, улаан буудай, гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, согтууруулах болон согтууруулах бус ундаа, савхин болон нэхий хувцас, хивс, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүн зэргийг Монгол Улсын үнийн мэдрэмжтэй, эмзэг бараа гэж үзсэн.

Улс орнуудын туршлагаас харахад, ЧХХ байгуулсны үр дүнд гол төлөв аж үйлдвэрийн барааны гаалийн тарифын хэмжээ маш сайн буурсан боловч хөдөө аж ахуйн салбарт зарим барааны тариф өндөр хэвээр байсаар байна. Энэ нь нэг талаас улсууд ХАА-н салбараа импортоос ихээхэн хамгаалдаг, нөгөө талаас үнийн мэдрэмж өндөр эмзэг бүтээгдэхүүн гэж үздэг учраас тарифыг чөлөөлөхгүй үлдээх нь бий.

Монгол Улсын импортын, БНСУ-ын экспортын харьцангуй давуу талын давхцалаас үзэхэд, БНСУ-аас ихэвчлэн нефть химийн бараа болон автомашин, машин механизм, тэдгээрийн эд анги, тамхи зэрэг 144 нэр төрлийн бараа импортлох боломж хамгийн өндөр байгаа ба одоогийн нөхцөл өөрчлөгдөхгүй бол эдгээр барааны гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх

хэлэлцээг БНСУ-ын талаас хийх нь тодорхой байна.

Монгол Улсын нэн тааламжтай гаалийн тарифын жагсаалтаас үзэхэд, нийт барааны 95.6% нь 5 хувийн, 1.4% нь 0 хувьтай, үлдсэн 3% нь 6.5-40 хувийн тарифтай. ТХЕХ-ийн XXIV заалтын хүрээнд гаалийн тарифыг чөлөөлөхдөө 5 хувийн тарифтай бараан дээр гол анхаарлаа хандуулж хэлэлцээ хийх нь чухал. Харин Монгол Улсын хөгжлийн бодлого, стратегийг хангах зорилгоор гаалийн тарифыг өндөр тогтоосон барааг хэлэлцээрээс гадуур үлдээх буюу тарифын хөнгөлөлт үзүүлэхгүй байх нь зүйтэй болов уу.

Түүнчлэн тарифын хэлэлцээ нь Барааны гарал үүсэл, Тарифын бус зохицуулалт, Амьтан, ургамлын эрүүл ахуй, Стандарт, техникийн саад тотгор, гаалийн үйл ажиллагаа гээд барааны худалдааны бүлгийн төдийгүй хөрөнгө оруулалт, оюуны өмч, үйлчилгээний худалдаа, өрсөлдөөн гээд хэлэлцээрийн бүх хэсгүүдтэй нарийн уялдаж байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Хэлэлцээ хийх баг нь хэлэлцээр байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохоос эхлэн судлаачид, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллаж, тарифын хэлэлцээг сайн хийснээр хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, түүнээс хүртэх үр ашиг, боломж нэмэгддэг.

Ном зүй

1. Balassa, B. (1965). *Trade liberalization and Revealed Comparative Advantage*. The Manchester School of Economic and Social Studies, 92-123.
2. Батнасан, Н., Отгонсайхан, Н., & Нарандалай, Д. (2012). *Худалдаа гол түнш орнуудтай худалдааны хэлэлцээр байгуулах боломж эрсдэл*. МУИС. Эдийн засгийн сургууль. Бодлогын судалгаа.
3. Эдийн засаг, хөгжлийн яам. (2023, September 26). *Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн яриа хэлэлцээг албан ёсоор эхлүүлээ*. <http://med.gov.mn/post/132824>
4. Гадаад харилцааны яам. (2021). *Монгол Улс, БНСУ хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны товч танилцуулга*. <https://mfa.gov.mn/>
5. International trade center. (2023a). *Export Potential Map*. <https://exportpotential.intracen.org/en/>
6. International trade center. (2023b). *Trade map*. <https://www.trademap.org/Index.aspx>
7. Kim, J. B. (2017, March 16). *A Legal Review of RTA Tariff Negotiations*. Ssrn.com. https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2934095
8. Монгол Улсын Засгийн газар. (2019). *Алсын хараа - 2050*. <https://vision2050.gov.mn/>
9. Otgonsaikhan, N., Doljin, M., & Sup, S.-U. (2014). The Opportunity Analysis of FTA between Mongolia and South Korea. *Journal of International Trade and Insurance*, 15(1), 49–62. <https://www.earticle.net/Article/A227472>
10. Otgonsaikhan, N., Nomintsetseg, U.-O., & Tsendsuren, D. (2022). *Changes in bilateral trade under the Mongolia-Japan Economic partnership agreement* (pp. 12–21). ERINA report plus. https://www.unii.ac.jp/erina-unp/archive/wp-content/uploads/2022/02/se16411_tssc.pdf
11. Отгонсайхан, Н. (2010). *Чөлөөт худалдааны хэлэлцээр ба Монгол улс*. ХҮДС-ийн ЭШ-ний бичиг –№19(10). – Х.114-123.
12. Отгонсайхан, Н. (2012). *Япон улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад анхаарч үзэх зарим асуудал*. Судалгааны тайлан.
13. Отгонсайхан, Н. (2013). *Роль таможенных пошлин в формировании государственного бюджета Монголии*. Izvestia.bgu.ru; Известия Иркутской государственной экономической академии (БГУ), – № 1 (87). – С.97-101. <https://izvestia.bgu.ru/reader/article.aspx?id=16362>
14. Plummer, M. G., Cheong, D., & Hamanaka, S. (2011). *Methodology for Impact Assessment of Free Trade Agreements*. Asian Development Bank. https://aric.adb.org/pdf/FTA_Impact_Assessment.pdf
15. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2023). *Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, нэр төрлийн ангиллаар, жилээр*. <https://www2.1212.mn/>
16. vip76. (2022). *2027 оноос буруу хүрдтэй авто машиныг улсын бүртгэлд*

- бүрмгэхгүй*. <https://vip76.mn/content/87428>
17. World Trade Organization. (1979, November 28). *WTO | legal texts - Marrakesh agreement*. [Www.wto.org](http://www.wto.org); WTO. https://www.wto.org/english/docs_e/legal_e/enabling1979_e.htm. Differential and more favourable treatment reciprocity and fuller participation of developing countries.
 18. World Trade Organization. (1994). *WTO | legal texts - Marrakesh Agreement*. [Www.wto.org](http://www.wto.org). https://www.wto.org/english/docs_e/legal_e/gatt47_02_e.htm#articleXXIV
 19. World Trade Organization. (2017). Free Trade Agreement between the Republic of Korea and Viet Nam (Goods and services). In *Committee on Regional Trade Agreements*. Report by the Secretariat. <https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=q:/WT/REG/371-1.pdf&Open=True>
 20. World Trade Organization. (2023). *WTO | Regional trade agreements*. Wto.org. <https://rtais.wto.org/UI/PublicMaintainRTAHome.aspx>

Economic Partnership Agreement between Mongolia and Korea: Some issues concerning the tariff negotiations

Otgonsaikhan Nyamdaa*

Ph.D

*Business School, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia,
otgonsaikhan@num.edu.mn*

Nomintsetseg Ulzii-Ochir

Ph.D

*Business School, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia,
nomintsetseg@num.edu.mn*

Delgerjargal Enkhtuya

*Business School, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia,
22m1num0060@stud.num.edu.mn*

Abstract: *Mongolia signed its first Economic Partnership Agreement (EPA) with Japan and the agreement entered into force in 2016. It has been agreed to conclude the next agreement with the Republic of Korea, and official negotiations have started from December 2023. In the framework of the traditional agreement, trade in goods and services, trade-related investment issues and intellectual property rights are discussed. Among these, the tariff negotiations are the core issue of the trade in good chapter and determine the benefits of negotiations through harmonization with other chapters. Therefore, it is important to conduct both qualitative and quantitative research in advance and make research-based decisions for customs tariff negotiations. In addition to studying the types of agreements signed by South Korea with other countries, the duration of negotiations, and the results of tariff negotiations with Vietnam, some issues to be considered in tariff negotiations were determined by analysing the revealed comparative advantage (RCA) index needed to develop Mongolia's proposals for tariff concessions' schedule and requests to be submitted to South Korea.*

Key words. *Reduction and elimination of customs tariffs, Preferential tariffs, MFN (most-favored-nation) tariff, Schedules of tariff concessions, Revealed comparative advantage*

<i>The day of submission:</i>	<i>2023.11.12</i>
<i>Completion of review:</i>	<i>2023.12.08</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2024.01.05</i>

* Corresponding author